



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 12 сарын 08 өдөр

Дугаар 632

Улаанбаатар хот

“Харгуй” төрийн өмчит хувьцаат компанийн
2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин,
хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Харгуй” төрийн өмчит хувьцаат компанийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг 1 дүгээр, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Компанийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд үндэслэн 2021 оны бизнес төлөвлөгөө болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд үүрэг болгосугай.

3. Төлөвлөгөөг үзүүлэлт бүрээр ханган биелүүлэх, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, өр, авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч, худалдан авалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг гүйцэтгэх захирал Н.Болдбаатарт даалгасугай.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА


Ц.БАЯР-ЭРДЭНЭ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн
63 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

**"ХАРГУЙ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
2021 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШИН**

Д/д	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	Хэмжих нэгж	2019 оны гүйцэтгэл	2020 оны		2021 оны төлөвлөгөө	Харьцуулалт	
				төлөвлөгөө	ХБГ		2021 төл/2020 ХБГ	2021 төл/2020 ХБГ
1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт	м.төг	2,019,793.80	2,050,000.00	2,042,403.90	2,160,000.00	105.8	117596.1
	Улсын чанартай авто зам засвар арчлалтын ажил	м.төг	875,613.70	1,380,000.00	1,526,203.90	1,780,000.00	116.6	253796.1
2	Орон нутгийн чанартай авто зам засвар арчлалтын ажил	м.төг	916,096.10	640,000.00	486,200.00	350,000.00	72.0	-136200.0
	Бусад орлого	м.төг	228,084.00	30,000.00	30,000.00	30,000.00	100.0	0.0
3	Нийт орлого	м.төг	2,019,793.80	2,050,000.00	2,042,403.90	2,160,000.00	105.8	117596.1
	Цэвэр борлуулалт	м.төг	1,860,034.60	2,040,000.00	2,032,403.90	2,040,000.00	100.4	7596.1
4	Түрээсийн орлого	м.төг	0.0	-	-	-	0.0	0.0
	Мал аж ахуйн орлого	м.төг	187.5	5,000.00	5,000.00	5,000.00	100.0	0.0
5	Бусад орлого	м.төг	159,571.70	5,000.00	5,000.00	5,000.00	100.0	0.0
	Нийт зардал	м.төг	2,004,771.90	2,012,450.40	2,004,450.50	2,115,212.10	105.5	110761.6
6	Үүнээс: Удирдлагын зардал	м.төг	245,255.90	266,694.20	251,693.70	261,038.20	103.7	9344.5
	Татварын өмнөх ашиг /алдагдал/	м.төг	15,021.90	37,549.60	37,953.40	44,787.90	118.0	6834.5
7	Цэвэр ашиг /алдагдал/	м.төг	13,519.70	33,794.60	34,158.10	40,309.10	118.0	6151.0
	Төсвийн төлбөрт нийт дүн	м.төг	245,333.70	349,087.20	332,076.60	364,714.60	109.8	32638.0
8	а/ Орлогын татвар	м.төг	1,562.00	3,379.50	3,795.30	4,478.80	118.0	683.5
	б/ НӨАТ	м.төг	82,500.00	118,500.00	118,500.00	118,500.00	100.0	0.0
9	в/ НДШ	м.төг	121,406.30	167,043.00	148,955.00	167,848.20	112.7	18893.2
	г/ Хүн амын орлогын татвар	м.төг	34,049.20	51,235.80	51,235.80	64,258.70	125.4	13022.9
10	д/ Үл хөдлөх хөрөнгийн татвар	м.төг	3,928.90	3,928.90	3,928.90	3,928.90	100.0	0.0
	е/ Гаалийн татвар	м.төг	0	-	-	-	0.0	0.0
11	ё/ Тээврийн хэрэгслийн татвар	м.төг	1,887.30	1,800.00	2,461.60	2,500.00	101.6	38.4
	ж/ Бусад татвар	м.төг	-	3,200.00	3,200.00	3,200.00	100.0	0.0
12	Төрийн өмчийн ногдол ашиг	м.төг	1,432.50	2,599.50	2,030.00	6,046.40	297.9	4016.4
	Нийт ажиллагсдын тоо	хүн	58.0	61.00	59.00	63.00	106.8	4.0
13	Нийт цалингийн сан	м.төг	468,278.60	596,582.30	595,820.30	671,392.90	112.7	75572.6
	Нэг ажиллагчийн дундаж цалин	м.төг	672.8	815.00	841.50	888.08	105.5	46.6
14	Борлуулалтын 1 төгрөгт ноогдох зардал	м.төг	0.99	0.98	0.98	0.98	100.2	0.0
	Хөрөнгө оруулалт	м.төг	78,916.80	95,890.90	85,475.50	69,728.00	81.6	-15747.5
15	Нийт авлага	м.төг	494,209.20	450,000.00	200,000.00	450,000.00	225.0	250000.0
	Үүнээс: Найдваргүй	м.төг	0	-	-	-	0.0	0.0
16	Нийт өглөг	м.төг	2,572.40	1,500.00	1,500.00	1,500.00	100.0	0.0
	Богино хугацаат өр төлбөр	м.төг	2,572.40	1,500.00	1,500.00	1,500.00	100.0	0.0
17	Урт хугацаат өр төлбөр	м.төг	0.0	0.0	0.0	0.0	0.00	0.0

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн
632 тогтоолын 2 дугаар хавсралт



**"ХАРГУЙ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
2021 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Д/д	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ /мян.төгрөг/	Нийт зардал /мян.төгрөг/
1	Шуурхай ажиллагааны хэсгийн барилгын их засвар	ш	1	63,228.00	63,228.00
2	Компьютер	ш	4	1,500.00	6,000.00
3	Принтер	ш	1	500.00	500.00
Нийт дүн					69,728.00